

## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ АРДЧИЛСАН ҮЗЭЛТНҮҮДИЙН БОДЛОГО, ҮЗЭЛ САНААНЫ ҮНДСИЙН ТУХАЙ /1926-1928/

С.К.Роцин

Оросын Холбооны улсын Москва хотын Дорно дахиныг судлах институт.

**Өгүүллийн товч утга:** 1926-1928 он Монголын түүхийн ахархан боловч нэлээд ээдрээ бэрхшээлтэй үе юм. Үүнийг “барууны хэлбэрэл”-ийн үе гэж нэрлэж ирэв. Өдгөө бид тэр үеийг огт өөрөөр үнэлж цэгнэх хэрэгтэй болж байна. Эдгээр жилүүд бол Монголын үндэсний ардчиллын туйл, түүнийг манлайлагчдын тэмцэл, бүтээлийн оргил болсон гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

**Түлхүүр үг:** Үндэсний ардчилсан үзэл, барууны хэлбэрэл, үндэсний эрх ашиг, үндэсний тусгаар тогтнол.

Үндэсний ардчилсан үзэлтнүүдийн бодлого, үйлдлэгийн онолын үндэс юу вэ? Энэ нь эдүгээ маш том, чухал асуудал тусгай судлагдахуун болж байгаа юм /1/. Үүнд холбогдох цогц баримт сэлт байхгүй хэдий ч тухайн үеийн үндэсний ардчилсан үзэлтнүүдийн төсөөллийг тодотгож өгөх зарим баримт, жишээнээс иш татан өгүүлэхийг оролдъя.

Бидний ойлгож байгаагаар бол үзэл санааны үндэс нь буддизмын гүнзгий нөлөөнд автсан Монголын өнгөрсөн үеийн сэтгэгчдийн уламжлалт ойлголтыг өөртөө агуулж байсныг хэлмээр байна. Улмаар өсөн нэмэгдэж байсан үндэсний ухамсрыг бас бүрэн тусгажээ. Түүхэн нөхцлийн улмаас үүсч бий болсон коммунист үзэл санаа монголын удирддагчдын нэг хэсэгт нэлээд хүчтэй, нөгөө хэсэгт бага зэрэг нөлөөлж байсан нь ардчилагчдын үзэл санааны үндэст тусгалаа олж байлаа. Үндэсний ардчилсан үзэл санаа нь монголын ард түмний түүх, уламжлалаар илэрхийлэгдэхийн зэрэгцээ улс орныхоо тухайн түүхэн тодорхой нөхцөл байдал, цаг үеийн онцлогийг харгалзан үзсэн шинжтэй байв.

Үндэсний ардчилсан үзэлтнүүд бүгдээрээ адилхан санаа бодолтой байгаагүй, нийтлэг болон онцлог шинж бүхий хэд хэдэн урсгалд хамрагдаж байжээ. Ардчилагчдаас хамгийн их тууштай нь “хуучин баруунтнууд”, “хуучинсаг үзэлтнүүд” гэж нэрлэгдсэн Б.Цэрэндорж, А.Амар, Ж.Цэвээн нар болон тэдний талыг баримтлагчид юм. 1926 оноос эхлээд үндэсний ардчилсан үзэлтнүүдээс ахмад үеийнхэн нь хуучин зүүнтэн байсан, намын дээд удирдлага Ц.Дамбадорж, Н.Жадамба нар болон тэдэнтэй шадарлагсадтай ойр дотно нөхөрлөх болов. Энэ нь монгол орны нөхцөл байдал, эх оронч бүх хүчний эв нэгдэл, зөвшилцлийн бодит шаардлага, дотоод гадаадын олон хүчин зүйлтэй холбоотой.

Тийнхүү ойр дотно нөхөрлөх болсны хамгийн тод жишээ бол ерөнхий сайд Б.Цэрэндоржийн 60 насны ойг тохиолдуулан зохион байгуулсан хүндэтгэлийн ажиллагаа юм /1927 оны II сарын эхээр/. Б.Цэрэндорж биеийн эрүүл мэндийн байдал муудсаны улмаас чөлөөлөхийг хүссэн өргөдөл I сард өгсөн нь уг үйл явдалд үлэмж их ач холбогдол өгөхөд хүргэжээ. Гэвч өргөдөл бичсэн жинхэнэ шалтгаан нь Коминтерний төлөөлөгчдийн дэмжлэг авсан хөдөөгийн залуу сөргөлдөгчдийн шаргуу үйл ажиллагаа байжээ. Цэрэндоржийн бичиж өгсөн өргөдөл нь намын удирдлагыг улам их тодорхой зүйл хийх, намын эв нэгдлийг улам бат бэх болгох талаар тустай гэж бодсон бөгөөд түүний энэхүү найдлага биелсэн байна. МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадорж Б.Цэрэндорж бол монголын улс төрийн амьдралд маш чухал хүн учраас ажлаас нь чөлөөлөхгүй гэсэн хатуу байр суурьтай байв. “Бүх хөндөгдсөн асуудлаар Цэрэндоржийн саналыг хуваалцаж байгаагаа харуулах ёстой” /2/ гэж намын тэргүүн үзэж байлаа. Цэрэндоржийн ойн баярын хүлээн авалт дээр хэлсэн



үгэндээ “Үндэсний чөлөөлөх хөдөлгөөнийг бэхжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс хэнийг ч албан тушаалаас нь чөлөөлөхгүй бөгөөд нам нэгдэн нягтарсан, дотор нь өргөөний болон хөдөөгийн бүлэг байх ёсгүй” гэж онцлон тэмдэглэжээ. Төв Хорооны даргын орлогч Н.Жадамба “Ихэнх хүмүүс Цэрэндоржийг хуучинсаг үзэлтэнд тооцож байна, гэвч энэ нь буруу ташаа ойлголт юм. Цэрэндорж бол Монголын үндэсний ахмад зүтгэлтэн” гэж үнэлсэн. Цэрэндоржийн хариу болгон хэлсэн үг нь улс төрийн ач холбогдолтой болов. Бүхий л амьдралынхаа туршид монголын ард түмний үндэсний сэргэн мандлын төлөө тэмцсэн, гэвч өнөөдрийг хүртэл үндэсний сэргэн мандал, монголын үндэс угсааг бэхжүүлэх гэсэн амьдралын минь ариун зорилго нам, эвлэл, армийнх хэмээн хуваагдаж байсанд итгэдэггүй явлаа /3/ гэж тэр мэдэгджээ.

1927 оны II сард үндэсний ардчилсан үзэлтнүүд монголын үндэсний сэргэн мандлыг хангах, өргөөний болон хөдөөгийн бүлэг, шинэ, хуучны ялгааг арилгахад, өөрөөр хэлбэл намын нэгдлийг хангахад чиглэсэн гол утга бүхий улс төрийн зорилтоо товчхон тодорхойлжээ. Энэ нь цоо шинэ зүйл биш байв. Үндэсний ардчилсан үзэлтнүүд бүр эрт, 1920, 1921 оноос эхлэн үндэсний сэргэн мандал, зөвшилцлийн тухай санаагаа илэрхийлж байсан. Гэвч тухайн тохиолдолд энэ санаа нь цоо шинэ мэт итгэл үнэмшилтэй сонсогдож байсан аж. Намын удирдагчид Б.Цэрэндоржийн талынхантай эв нэгдэлтэй байгаагаа харуулж чаджээ. Коминтерний төлөөлөгчид, хөдөөгийн бүлгийн сөргөлдөгчдийн ширүүн довтолгоонд өртсөн үндэсний ардчилсан үзэлтнүүд улс төрийн жанжин шугам, эгнээний нэгдэл нягтралаа хамгаалахад багагүй бэрхшээлтэй тулгарч байсан байна. 1928 оны II сард Б.Цэрэндорж нас барсны дараа намын удирдлагууд ба ерөнхий сайд болсон А.Амар, тэр ч байтугай Ц.Дамбадорж ба Н.Жадамба нарын хооронд заримдаа зөрөлдөөн, аливаа асуудалд хандахад ялгаа гарах болжээ. Гэвч үүнийг хялбархан засч болох байлаа. 1926-1928 онд хэрэгжүүлж байсан үндэсний ардчилсан ерөнхий мөрийн хөтөлбөрийн тухай ярьж болно гэж үзэж байна.

Мөрийн хөтөлбөрийн гол үндсийг төрийн бэхжилт, тусгаар тогтнолын ололт амжилтаар дамжуулан үндэсний сэргэн мандлыг бий болгох гэсэн санаа бүрдүүлж байна. Чухамхүү энэ нь юуны өмнө, намын удирдлага, бас Цэрэндорж Амарын бүлгийг нэгтгэж байв. Бас хөдөөгийн бүлгийн сөргөлдөгчид ч тухайн мөрийн хөтөлбөрийн шаардлагыг эсэргүүцэж чадаагүй байна.

Тэр үеийн монголын удирдагчдын хэлсэн үгэнд үндэсний сэргэн мандлын тухай ямар бодол санаа байсныг товч тодорхой бичиж үлдээжээ. А.Амар “Монголын түүх” номондоо “Чингис хааны үед нэн их хүчирхэг байсан монгол аймгууд хожим бутарч, бусдын нөлөөнд автсанаар харийнхны эрх ашиг, бодлогыг хэрэгжүүлэхэд өөрсдийн бүх хүчийг сарниулсан явдал тун харамсалтай... Монгол хүн бүрийн сэтгэлд өөрийн төр, улс үндэстнээ өөд нь татах итгэл найдвар байв. Бид, хойд монголчууд, үндэсний тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө тасралтгүй тэмцэн Монголын төрт ёсыг дахин сэргээн мандуулж өнөө болон ирээдүйн амжилтын үндэс суурийг тавьж байна” /4/ гэжээ.

Монголын төр, түүний хууль дүрэм ямар байх ёстой вэ? Тунгаан үзэхэд янз бүрийн үзэл бодол байсан бололтой. Нэрд гарсан үзэл сурталчдын нэг Ж.Цэвээн “Хятадын, ЗСБНХУ-ын өмгөөлөл ч биш, гэвч Швейцари шиг төвийг сахисан улс байх ёстой” /5/ гэсэн бодолтой байв.

Үүнд монголын аль нэгэн ястан үндэстнийг биш, бүх монгол туургатныг нэгтгэх замаар үндэсний сэргэн мандлыг бий болгох юм гэсэн нэгэн чухал өөр санаа оршиж байна. Нэгтгэх тухай санаа бодол 1911 онд ч, 1921 онд ч бодит бус, бүтэшгүй байсан бөгөөд янз бүрийн урсгалд хамаарах монголын зүтгэлтнүүдийн оюун санааг эзэмдэж, олон баримт бичигт тусгалаа олсон юм. Ц.Жамсран “Үндэсний чөлөөлөлт, сэргэн мандлыг зөвхөн дотоод монголд төдийгүй, Гадаад Монгол, Хөх нуур, Синьцзян, Баргат хүсч мөрөөдөж байв.

Үндэсний хувьсгалт хөдөлгөөний цаашдын өрнөлтийн үр дүнд монгол аймгуудын холбоо аажим аажмаар үүсч бий болов" /6/ гэж бичсэн байна.

Монголын сэргэн мандлыг ханган бэхжүүлэх нь үндэсний өвөрмөц байдал, үндэсний зөвшилцөл, тэвчээртэй байдалд хүрэх сонирхлыг бүх талаар хамгаалах явдал юм. А.Амар "Монгол аймгуудын хувьд өөрийн ахуй байдал, хэвшлийг эрхэмлэн, харийн дарлал мөлжлөггүй, бусдын нөлөөнөөс ангид, энх тайван, эв нэгдэлтэй амьдрах нь хамгийн сайн хэрэг. Аливаа аймгийн ахуй хэвшил нь түүний хувьд дадсан, зохицсон байдаг ба бусад аймгийн ахуй хэвшил нь хичнээн сайхан байсан ч түүнд зохицоход бэрхшээлтэй" /7/ гэж тэмдэглэжээ.

Үндэсний зөвшилцлийг хэрэгжүүлэх тухай санаа бодол Ц.Дамбадоржийг эзэмдэж байсан хэдий ч улс төрийн тэмцлийн халуун гал дунд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байв. Тэр 1926, 1927 онд сөргөлдөгчдийн зөрчилдөөнийг устгаж арилгахыг оролдож байсан, хожим нь нам, төрийн ажлаас цөөнхийг халсан гэж буруугаа хүлээжээ /8/.

Монголын нийгэм-эдийн засгийн хөгжлийн арга замын тухай үндэсний ардчилсан үзэлтнүүдийн бодол, тэдний сэргэн мандлын талаарх үзэл санаатай нягт холбоотой юм. ЗСБНХУ, Коминтернтэй холбоотой түүхэн тодорхой нөхцөлд үндэсний ардчилсан үзэлтнүүд хөрөнгөтний бус хөгжлийн зам, социалист ирээдүйн эсрэг ил тод тэмцэл өрнүүлээгүй бөгөөд чухамхүү иймэрхүү хөгжлийг зохих хэмжээнд дэмжигчид мөн байв. Үүний зэрэгцээ орон нутгийн онцлог байдлыг бүрэн тооцох, албан ёсны марксист баримтлалын тухай тайлбар, ойлголтоо боловсруулахыг эрхэмлэж байлаа. Ц.Дамбадорж 1938 онд МАХН-ын программын төсөлд: "Монгол улс капиталист хөгжлийн замаар замнах ёсгүй" гэж оруулсан. Энэ үед Коментернд хандах хандлага нь түүний удирдлагыг хүлээн зөвшөөрснөөр биш, Коминтернийг таньж мэдэх хүсэл эрмэлзлэлээр тодорхойлогдож байв. Монголын ард түмний хөдөлгөөн бол дэлхий дахины пролетари нарын хөдөлгөөний хэсэг биш, Дорно дахины ард түмний хөдөлгөөний нэгэн хэсэг гэж үзэж байв. Монгол улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэх явдлыг л үндсэн гол зорилт болгон дэвшүүлж байв /9/.

Ж.Цэвээн "Монголын социализмын" өвөрмөц онцгой байдлын тухай маш дэлгэрэнгүй бичсэн. Тэр ангийн ялгаралын сул дорой хөгжил, үндэсний пролетари, хөрөнгөтөн байхгүй, нүүдлийн аж төрөх ёс бүхий өвөрмөц феодализм, ардын аж ахуйн хагас натурал байдал, гадаадын худалдааны болон мөнгө хүүлэгч капиталуудын хүчирхэг нөлөө, бусад зүйл зэрэг монголын онцлог шинж чанарыг харгалзан үзэхийг уриалжээ. "Дээр дурьдсан хүчин зүйлүүд нь Монголын хувьд улсын капитализм ба хоршооллыг дамжин социализмд хүрэх ёстойг харуулж байна". Энэ цаг үед хоршоолол гүйлгээний хүрээнээс эхлэх ёстой ба дараа нь аажим аажмаар үйлдвэрлэлийн хүрээг хамрах болно /10/.

Үндэсний ардчилсан үзэлтнүүд татвар-мөнгө, зах зээлийн харилцааг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн таваарлаг чанарыг дээшлүүлэх, өмчийн олон хэлбэрийг бий болгохын төлөө тэмцэв. Чинээлэг болон ардын хувийн аж ахуйг дэмжих явдал чухал гэж үзэв. Салбарын бүтцийн хувьд мал аж ахуй тэргүүн байр эзэлж, дэлхийн зах зээлд түүхий эд гаргах явдал байлаа. Өнөөгийн суурь хөрсөнд үндэсний худалдаа, аж үйлдвэр, барилга, тээврийг аажмаар хөгжүүлэх зорилт дэвшүүлэв.

Ардчилсан үзэлтнүүдийн онол дахь бас нэг чухал бүрдлийг тэмдэглэн хэлье. Тэд "дийлэгдэшгүй хүнд үүрэг авахгүй, хэтэрхий хүч чадал гаргахгүй, өндрийн харайлт хийхгүй" гэж тооцоолсон. Тун алгуурхнаар, урьдчилсан нөхцөл байдлыг бий болгон бүрдүүлэх замаар урагшаа хөдлөх ёстой гэж үзэв /11/.

Үндэсний ардчилсан үзэлтнүүд дотоод асуудлыг шийдвэрлэхдээ маш хянуур, уян зөөлөн байдлаар ханддаг байв. Н.Жадамбын хэлснээр бол "ангийн тэмцэл хийхгүйгээр тайван замаар социализм байгуулж болно" гэж ардчилсан



үзэлтнүүд үзэж байв /12/. Ангийн тэмцлийг хурцатгаснаар нам, үндэстний хүчийг сарниулна. "Шинэ амьдрал цогцлон бүтээх эрх чөлөөтэй, уужуу тайван хөдөлмөр эрхлэхэд энх амгалан байдал бүрдүүлэх явдал зайлшгүй" гэж үзэж байсныг Ж.Цэвээн тэмдэглэжээ /13/.

Соёл боловсролд хандах харьцаа нь үндэсний сэргэн мандлын тухай нийтлэг ойлголтоор тодорхойлогдож байв. "Соёл боловсрол нь өөрийн хэлбэр, агуулгаараа монголын үндэсний соёл боловсрол байх ёстой" хэмээн тэрээр бичжээ. Энэ нь гадаадын, олон улсын соёл боловсролын урсгал, чиглэл, ололт амжилтыг нэвтрүүлэхийг үгүйсгээгүй. Гэвч "шинэ үзэл санааг хүлээн авах явдал тулган хүлээлгэх буюу засаг захиргааны нөлөөллийн замаар бус, бүх Азийн, монголын үндэсний соёл боловсролыг иш үндэсгүй үгүйсгэх замаар биш, суртал ухуулгын сайн дурын, зүй ёсны нөлөөллийн замаар хийгдэх ёстой". Соёл боловсрол дахь үндэсний шинжийг агуулсан бүх зүйлийг хамгаалах, сургууль, хэвлэлийн газар, эрдэм шинжилгээ, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд үндэсний мөн чанарыг нэвтрүүлэхийн төлөө тэмцэл өрнүүлэх ёстой байв /14/.

Гадаад бодлого, түүний шинж чанарт мөн л үндэсний сэргэн мандлын тухай зорилтуудаар тодорхойлогдож байлаа. Монгол улс олон улсаас хөндий байдлаасаа ангижирч, бусад улс гүрэнтэй өргөн цар хүрээтэй харилцаа хөгжүүлэх ёстой байв. Тэдэнтэй тэгш, харилцан ашигтай харилцаа хөгжүүлэх хэрэгтэй. Энэ нь ЗХУ-тай харилцах харилцаанд илэрч байлаа. Н.Жадамба, А.Амар нар энэ талаар тусгайлан саналаа хэлж байжээ. "ЗХУ-тай худалдаа, аж ахуйн талаар харилцах харилцаанд нэн тэгш эрхтэй байх ёстой гэсэн бодлогыг би баримталж байна. Хэн өндөр үнээр авч байна, түүнд түүхий эдээ худалдаж, хэн хямд үнээр зарж байна, түүнээс бараагаа худалдан авах хэрэгтэй..." /15/ хэмээн Н.Жадамба бичсэн байна.

Үндэсний ардчиллагчид өөрсдийн үзэл суртлаа хэрхэн үнэлсэн бэ? гэвэл тэд Коминтерний үйл ажиллагааг сайшаасан, намын төлөөлөгчийнхээ хувьд коммунист үзэл бодлоос бүрмөсөн ангижран салж чадаагүй байжээ. Энэхүү үзэл бодлыг тууштай баримтлагч хэмээн өөрсдийгөө нэрлэсэн намын гишүүд цөөнгүй байлаа. Гэвч тэр үед МАХН-ын удирдагчид эрс шууд томъёолол хийх, намын мөрийн хөтөлбөрийн заалтанд марксист зарчим албан ёсоор оруулах гэж яарч шамдаагүй нь анхаарал татаж байна. Намын IV их хурал дээр мөрийн хөтөлбөрийг түр баталж, V, VI их хурал дээр байнгын хөтөлбөр батлах ажлыг хойшлуулжээ. Ц.Дамбадоржийн байр сууринд гарсан өөрчлөлтүүд тухайн үеийн байдлыг ойлгоход хэд хэдэн зүйл тодотгож өгч байна. 1925 онд зүүнтний тэргүүн байсан Ц.Дамбадорж Коммунист интернационалын гүйцэтгэх хороонд /КИГХ/ хийсэн илтгэлдээ: МАХН-ыг коммунист нам болгон өөрчлөх асуудал тавьжээ. КИГХ нөхцөл байдал бүрдээгүй учир үгүйсгэсэн байна. Энэ тухайд бас 1927 онд Дамбадорж "Иймэрхүү байдлыг хүлээн зөвшөөрсөн нь Коминтерноос миний улс төрийн чиг шугамыг буруушаасан, түүнчлэн Монголд Коммунист нам үүсч бий болох урьдчилсан ямар ч нөхцөл байхгүйг мэдэгдэж байсан Жамсран, Цэрэндорж нарын байр суурийг бэхжүүлсэн баримт мөн. Энэ бүхэн надад нэгийг бодогдууллаа. Ардын нам өөрийгөө устгаж үгүй хийгээгүй гэж Коминтерн үзсэн учир би, Дамбадорж, радикал хөрөнгөтний намын зүтгэлтэн байх ёстой. Ардын нам үндэсний агуулгыг урьтал болгох ёстой, өөрийн улс төрийн чиг шугамыг ашигтайгаар өөрчлөх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийв" /16/ гэжээ.

Үндэсний ардчилсан үзэлтнүүд үзэл суртлын талаар ямар байр суурьтай байсныг ойлгохын тулд бас нэг чухал зүйлийг тэмдэглэн хэлье. Тэд бурхны шашныг хэрхэн үзэж байсан тухай авч ярья. Ардчилсан үзэлтнүүд сүм хийд эдийн засаг, хүмүүсийн оюун санаанд хүчтэй нөлөөлж байсныг иш үндэс болгожээ. Хүн амын олонх нь лам хувраг хүн ариун гэгээн хэмээн үзэж, намын удирдагчдын ихэнх нь тэднийг бишрэн шүтэж байв. Тиймээс ч Ж.Цэвээн бурхны шашин ардын намын сурталтай харшлах зүйлгүй учраас "шашныг ариунаар

мандуулан хөгжүүлэх" ёстой гэж бичжээ. Үндэсний ардчилсан үзэлтнүүд бурхны шашин, сүм хийдэд хэрхэн хандаж байсан талаар 1926 онд батлан гаргасан шашныг төрөөс тусгаарласан хуулинд "Бурхан Шигимуний шашныг дотночлон хүндэтгэн үзэх тул тус суртлыг сахих, суралцах, дэлгэрүүлэх явдлыг хууль ёсны дотноо батлан хамгаална" /17/ гэжээ.

Ардчилсан үзэлтнүүдийн энэхүү онолын үзэл бодлууд тэдний практик үйл ажиллагаанд бодитойгоор тусгалаа олж байжээ. Зарим нэг жишээ дурьдаж болох юм. Эдийн засгийн бодлогын нэн тэргүүн зорилт нь эдийн засгийн олон хэвшлийг хөгжүүлэх, улс, хоршоолол, хувийн аж ахуйг урамшуулан тэтгэх явдал байв. Тэд 1926 онд "Баяжигтун" уриа дэвшүүлжээ. Коминтерний шүүмжлэлийн улмаас намын удирдагчид уг лозунгаас хөндийрсөн хэдий ч энэхүү уриа нь тодорхой хүрээнд хэрэгжиж байв. 1933-1934 онд шинэ эргэлтийн бодлого хэмээн уг уриаг дэвшүүлсэн нь улс орны хэрэгцээнээс урган гарсан юм. Монценкоп, зөвлөлтийн худалдааны байгууллагууд зэрэг гадаадын пүүсүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, дотоодын зах зээлийн хэвийн ажиллагааг хангах, өрсөлдөөн бий болгох нөхцлийг бүрдүүлэн ажиллах ёстой байлаа. Хар, шар феодалуудын эдийн засгийн байр, суурийг ямар нэгэн байдлаар хөндөөгүй ч шашны асуудалд маш болгоомжтой хандаж байв. Намуун, дөлгөөн, аажуухан, анхаарал сэрэмжтэй ажилласан нь улс орны амгалан тайван байдлыг сахин хамгаалахад тус болжээ.

Үндэсний ардчилсан үзэлтнүүд тохиолдсон саад бэрхшээлийг тухайн нөхцөл, өвөрмөц онцлогийг харгалзан даван туулж байлаа. Хөрөнгөтний бус хөгжлийн замын тухай бодлогыг хэн ч үгүйсгээгүй бөгөөд ихэнх нь энэ замаар замнах ёстой гэж үзэж байлаа. Гэвч орон нутгийн нөхцөл байдалд зохицуулах, үндэсний онцлогийг харгалзан хэлбэр, агуулгыг өөрчлөх зэрэг оролдлогыг хянан үзэх ёстой байв.

Монгол улс олон улсын байдлаа бэхжүүлэхийн тулд багагүй хүчин чармайлт гаргажээ. Хятадын шударга дэвшилт зүтгэлтнүүд, японы дипломатууд, барууны орнуудын тодорхой хүмүүстэй харилцаа тогтоох талаар нэлээд ажил хийв. Ц.Дамбадорж 1926 онд Герман, Франц, Итали улсад очсоныг анхаарахгүй байж болохгүй. Энэ айлчлал нь Дамбадоржид барууны орнуудын аж төрөх ёсны талаар тодорхой ойлголт төрүүлж, гүнзгий сэтгэгдэлтэй иржээ. Европын орнуудтай хэлхээ холбоо тогтоох анхны алхмууд хийгдэж, Герман, Франц улсад суралцуулахаар хэсэг залуучуудыг явуулав.

Үндэсний ардчилсан үзэлтнүүд ЗХУ-тай байгуулсан хамтын ажиллагаа нь улс орны тусгаар тогтнол, эдийн засгийн хөгжлийн ололт амжилтнуудын баталгаа хэмээн үзэж байсан учир түүнд нэн ач холбогдол өгч байв. Гэвч тэд өөрсдийн тусгаар тогтнолын эрхээ бүх талаар хамгаалж, харилцаанд бий болсон гажгийг арилгахыг эрмэлзэж байлаа. Тухайлбал, 1926 оны эхээр Москва хотноо Н.Жадамба, А.Амар нарын байгуулсан хэлэлцээнд эдийн засгийн хамтын ажиллагаанд тэгш эрхтэй байхад чиглэгдсэн хэд хэдэн чухал санал дэвшүүлсэн юм /18/.

Үндэсний ардчилсан үзэлтнүүдийн номлож, хийж байсан зүйлээс хэд хэдэн ажил Зөвлөлтийн болон Коминтерний төлөөлөгчдийн дургүйцлийг хүргэж байжээ. Монголын удирдагчдын бодлогыг "барууны аюул", "барууны хэлбэрэл", "Хөрөнгөтний бус хөгжлийн замын бодлогоос ухарсан нь", "ухралт хийсэн нь", "ЗХУ-тай тогтоосон хамтын ажиллагаанаас ухарсан нь" гэх мэтээр ангилж болно. Иймэрхүү ангиллын урьдчилан хийх нь одоо эргэлзээгүй юм. Монголын удирдагчид үндэсний эрх ашиг, улс орны амин чухал асуудлыг иш үндэс болгон, бие даасан байдлаа бэхжүүлэхийг эрмэлзэж байсан бол Коминтерний болон зөвлөлийн төлөөлөгчид өөрсдийн интернациональч тулган шаардалтыг хэрэгжүүлэхийг урьтал болгожээ. Үндэсний эрх ашиг ба "интернациональч" зорилт нь ав адилхан байсангүй. Энэ нь МАХН-ын Төв Хороо, Коммунист



Интернационалын Гүйцэтгэх хороо хоорондоо зөрөлдөхийн эх сурвалж, "баруунтан" гэж зэмлэн буруушаах шалтгаан болж байжээ.

Тэглээ ч үндэсний ардчилсан үзэлтнүүдийн үзэл санаа, үйл ажиллагаа зөвлөлтийн улс төрийн бодлого, марксист албан ёсны заалтуудтай ямагт зерчилдөж байгаагүй, зарим асуудлын талаар нэгдмэл санаа бодолтой байв. Хоёр талын сайтар тунгаасан, бодитой харилцааны үед харилцан ойлголцох бүрэн боломж байлаа. Гэвч бодит амьдрал дээр энэ нь биелэгдэшгүй зүйл байсан аж. Хэрэв 1926 он хоорондын харилцааны хувьд харьцангуй тайван үе байсан бол, цаашид тэмцэл хүчтэй өрнөн улам бүр хурцаджээ.

1928 оны X сарын 23-ны өдрөөс XII сарын 11-ний өдөр хуралдсан МАХН-ын VII их хурал дээр үндэсний ардчилсан үзэлтгүүд ялагдсан юм. Ялагдалд 1928 оны IX сарын 14-ний өдөр Коммунист интернационалын гүйцэтгэх хорооноос монголын тухай асуудлаар гаргасан тогтоолыг удирдлага болгосон Коминтерний төлөөлөгчид их үүрэг гүйцэтгэжээ. Энэ төлөөлөгчдийн дэмжлэгтэйгээр хөдөөнийхэн хэмээх зүүний сөргөлдөгчид засгийн эрхийг гартаа авчээ.

Гэвч үндэсний ардчилсан үзэлтнүүд улс төрийн тавцангаас зайлаагүй. Зүүний туршилт нурсны дараа 1929-1932 онуудад хэрэгжүүлсэн "шинэ эргэлтийн бодлого" олон зүйлээр 20-иод оны үеийн үндэсний ардчилагчдын онол, практик үйл ажиллагааг санагдуулж байжээ. Тэгээд ч түүх Монголын хөгжлийн тухай үндэсний ардчилсан хөтөлбөрийн амьдрах чадвар, ач тустай болохыг батлан харуулсан бүлгээ.

**Резюме:** 1926-1928 гг. – краткий, но весьма сложный и драматичный период монгольской истории. Он известен был ранее как период "правого уклона". Теперь мы иначе оцениваем то время. Эти годы с полным основанием можно считать апогеем монгольской национальной демократии, вершиной творчества и борьбы ее лидеров.

### Ном зүй

1. Оохнойн Батсайхан. Ориентировочная концепция национально-демократического развития Монголии и борьба за ее претворение в жизнь /1921-1932/. Автореферат дисс. на соискание ученой степени канд.ист.наук. УБ., 1995-аас үзнэ үү.
2. Российский центр хранения и изучения документов новейшей истории /РЦХИДНИ/, ф.495, оп.152, д.50, л. 8.
3. Мөн тэнд, д 57, л.6-8.
4. Архив внешней политики Российской Федерации /АВП РФ/, ф.111, оп.18, д.4, п.15, л.5-6
5. РЦХИДНИ, ф.495, оп.152, д.125, л.87
6. Мөн тэнд
7. АВП РФ, ф.111, оп.18, д.4, п.15, л.5
8. РЦХИДНИ, ф.495, оп.152, д.125, л.87
9. Мөн тэнд, д.64, л.27
10. Мөн тэнд, д.119, л.204-205
11. Мөн тэнд, л.205
12. Мөн тэнд, д.125, л.82
13. Мөн тэнд, д.119, л.205
14. Мөн тэнд
15. Мөн тэнд, д.125, л.83
16. Мөн тэнд, д.57, л.20-21

17. Цит.по: Очерки истории Монгольской народно-революционной партии. Пер.с монг., М., 1971., с.110
18. Ц.Навагчамба. Наваандоржийн Жадамба- Буруугүй "буруутнууд". Зуунмод хот, 1993., д 40

**Өгүүллийг орос хэлнээс орчуулсан:** Г.Гантөмөр  
М.Баттөмөр